

**МОНГОЛ УЛСААС ГАДААДЫН ЗАРИМ УЛСТАЙ ДИПЛОМАТ ХАРИЛЦАА
ТОГТООХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛҮҮДИЙГ ХЭЛЭЛЦСЭН
ТУХАЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНООС
ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 01 дүгээр
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн
Сү.Батболд**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ!

Монгол Улсаас гадаадын зарим улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг Монгол Улсын Засгийн газраас 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2014 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.


Монгол Улсаас Антигуа Барбуда Улстай, Бүгд Найрамдах Бурунди Улстай, Эритри Улстай, Бүгд Найрамдах Палау Улстай, Бүгд Найрамдах Сьерра Леон Улстай, Бүгд Найрамдах Суринам Улстай, Бүгд Найрамдах Того Улстай, Бүгд Найрамдах Вануату Улстай, Ямайка Улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд тус тус санал нэгтэй дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гадаадын зарим улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцсэн тухай Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн, төслүүдийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ц.ОЮУНБААТАР